



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 02

Мөрөн

“Эх хэл, бичиг” аймгийн хөтөлбөр батлах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Эх хэл, бичиг” аймгийн хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөв, үндсэн чиглэлд тусган шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг дарга /А.Эрдэнэбаатар/-т даалгасугай.
3. “Эх хэл, бичиг” боловсролын хөгжлийн хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг холбогдох хууль, журмын дагуу жил бүрийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөнд тусгаж хэрэгжүүлж ажиллахыг сумдын ИТХ, Засаг дарга нарт даалгасугай.
4. Аймгийн нийт иргэд, хүүхэд залуучуудад бүтээлчээр сэтгэж, оюунлаг амьдрахын ач тусыг ухамсарлуулан нутаг орноороо бахархах үндэсний хэл, бичиг соёлоо эрхэмлэн, эх хэлний боловсролын чанар, хэрэглээ, харилцааны соёлын түвшинг дээшлүүлэхийг нийт төрийн албан хаагчид, аймаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд даалгасугай.
5. Энэхүү тогтоолын биелэлт үр дүнг тооцож аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд жил бүр танилцуулж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын дарга /Г.Төмөрбаатар/, аймгийн Боловсрол, соёлын газрын дарга /Н.Баатар-Очир/ нарт даалгасугай.
6. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Цогтоо/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.БОЛДБААТАР

010024

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны  
01 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар  
тогтоолын 01 дүгээр хавсралт

## “ЭХ ХЭЛ, БИЧИГ” ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨТӨЛБӨР

### ***Нэг. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, шаардлага***

Монгол бичиг бол хүн төрөлхтний бүтээсэн оюуны соёлын салшгүй нэгэн хэсэг бөгөөд энэхүү бичгийг монголчууд XIII зуунаас хэл аялгуундаа тохируулан хэрэглэж, улам төгөлдөржүүлэн олон зүйл мэдлэг ухааны туурвил бүтээлийг бий болгожээ. Монголын ард түмний соёлын өв болсон монгол бичгийг хадгалан хамгаалж, эзэмшин хэрэглэж, төгс төгөлдөр болгох нь хүн төрөлхтний өмнө бидний хүлээсэн үүрэг мөн.

Монгол бичиг XIII зуунаас эхлэн 1950 он хүртэл монголчуудын 750 гаруй жил хэрэглэсэн албан ёсны бичгийн нэг байв.

1950-иад оноос хойш 50 гаруй жил төрийн албан хэргийг кирил бичгээр хөтөлж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, хот, аймаг, дүүрэг, сум, хороодын тамгыг монгол бичгээр үйлдэн хэрэглэх болоод 20 шахам жил боллоо. Энэ нь монгол бичиг төрийн бичгийн үндсэн үүргээ гүйцэтгэсээр байгаагийн нэг бодит баримт юм.

Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангид 1980-аад оны дунд үеэс монгол бичгийг заах болсон нь түүнийг залуу үед өвлүүлэх нэг алхам болсон бол 1990-ээд оны эхээр Монгол оронд өрнөсөн ардчилсан хөдөлгөөн нь үндэсний бичиг үсгээ дахин сэргээх боломжийг нээсэн билээ. “БНМАУ-д албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах болон түүний бэлтгэл ажлыг хангах тухай” Улсын Бага хурлын 1991 оны 36 дугаар тогтоол гарч, түүнийг хэрэгжүүлэх өргөн далайцтай ажил зохиогдсон байна. Улсын Их хурлын 1995 оны 43 дугаар, 2008 оны 196 дугаар тогтоолоор Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг баталсан.

2004 онд БСШУЯ-наас Монгол хэл, уранзохиолын бага дунд боловсролын стандартыг боловсруулан өдгөө бид хэрэглэж байна.

2015 онд Монгол хэлний тухай хууль батлагдаж нийтээр мөрдөж байна. Тус хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна гэж заасан.

Иймд төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагуудын албан хаагчид үндэсний бичиг үсгээ судлан, хэрэглээний чадвараа нэмэгдүүлэх шаардлагатай боллоо.

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 37-р тогтоолоор үндэсний бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлж, иргэдийн чадварыг дээшлүүлэх талаар шийдвэр гарсан. Гэвч монгол хэлний бичгийн хэлний хэм хэмжээ зарим талаар алдагдаж, гадаад үг, хэллэг, нэр томъёоны хэрэглээ ихсэж, төрийн албан хэргийн хөтлөлт, албан газар, аж ахуй нэгжүүдийн хаяг, зар сурталчилгаанд тавигдах шаардлага бүрэн хэрэгжихгүй байгаа сөрөг зүйлүүд гарсаар байна.

Иймд “Эх хэл, бичиг” Хөвсгөл аймгийн хөтөлбөрийг боловсруулж үндэсний бичиг үсгээрээ бахархан, аман болоод бичгийн хэлээ цэвэр ариун, яруу тансаг, утга төгс байлгаж, эх хэлээрээ манлайлагч аймаг болохыг зорилоо.

### ***Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зорилтууд***

Үндэсний хэл, бичиг соёлоо эрхэмлэсэн орчин бүрдүүлж, нийт иргэд, суралцагчдын эх хэлний боловсролын чанар, хэрэглээ, харилцааны соёлын түвшинг дээшлүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

### ***Гурав. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж байна:***

- 3.1. Багш нарын эх хэлний боловсролын түвшинг дээшлүүлнэ.
- 3.2. Хүүхэд нэг бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлнэ.
- 3.3. Эх хэл бичгийн зөв хэрэглээ бүхий орчин бүрдүүлнэ.
- 3.4. Иргэдийн монгол хэл бичгийн хэрэглээний чадварыг сайжруулна.

### ***Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:***

#### **1-р зорилтын хүрээнд:**

**3.1.1.** Монгол хэлний багш нарын хамтын ажиллагааг “Аравт”-ын зохион байгуулалтаар хөгжүүлэх.

**3.1.2.** Монгол хэлний багш нарын мэргэжлийг үе шаттайгаар дээшлүүлэх төлөвлөлт хийж ажиллах.

**3.1.3.** Мэргэжлийн багш нараар дамжуулан бусад мэргэжлийн багш нарын монгол хэл бичгийн хэрэглээний чадварыг ахиулна.

**3.1.4.** Эх хэлний багш нарын судалгааны ажлыг дэмжиж, боловсролын түвшинг ахиулна.

**3.1.5.** Монгол хэлний багш нарын “Арга зүйн баг” бүрдүүлж ажиллана.

**3.1.6.** Мөрөн сумын монгол хэлний багш нарыг “Эх хэлний цаг”-тай болгож ажиллана.

**3.1.7.** Багш нарын сургалтын шилдэг арга зүй, технологи, туршлагыг түгээн дэлгэрүүлж, цахим мэдээллийн санд авна.

**3.1.8.** Баруун болон төвийн бүсийн аймгийн мэргэжлийн багш нартай хамтран ажиллана.

#### **2-р зорилтын хүрээнд:**

**3.2.1.** ЕБС-дад “Бичиг- урлаг” уран бичлэгийн дугуйлан хичээллүүлнэ.

3.2.2. “Эх хэл бидний бахархал” үндэсний бичиг соёлын өдрийг тусгай удирдамжаар тэмдэглэх.

3.2.3. “Шидэт уянга”, “Цэнхэр алс” яруу найргийн дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

3.2.4. “ Хэлц үгээр хэлэлцье”хүүхдийн цуврал нэвтрүүлэгтэй болно.

3.2.5. Эх хэлний тулгуур дөрвөн чадварыг хөгжүүлэх дугуйлангийн суралцагчдын уулзалт, мэтгэлцээн зохион байгуулна.

3.2.6. Монгол улсын хөдөлмөрийн баатар, гавьяат багш Т.Дашцэдэнгийн нэрэмжит Эх хэлний баярыг 4 жилд нэг удаа аймгийн үндсэн чиглэлд тусгаж хэрэгжүүлнэ.

3.2.7. Суралцагчдын эх хэлний мэдлэгийн түвшинг үнэлэх жишиг даалгаврыг боловсруулж хөндлөнгийн үнэлгээ хийнэ.

3.2.8. 5-12-р ангийн сурагчид бага, дунд ангийн багш нарын олимпиадыг Монгол улсын гавьяат багш Д.Батсуурийн нэрэмжит болгон зохион явуулна..

3.2.9. ЕБС бүрийн эх хэл бичгийн чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт үр дүнг тооцож ажиллах.

3.2.10. Бүх мэргэжлийн багш нараас монгол хэл бичгийн чадварын түвшинг үнэлэх шалгалт авч ажиллах.

### **3-р зорилтын хүрээнд:**

3.3.1. Төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, гудамж, талбайн хаяг, бүтээгдэхүүний шошгыг кирил болон үндэсний бичгээр зөв үйлдэхийг захирамжилж хэрэгжүүлэх

3.3.2. Монгол хэл, бичгийн жишиг кабинетийг сумын сургууль бүрт орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр байгуулж, ажиллуулна.

3.3.3. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын ажилтнуудын зөв бичгийн дүрмийн хэрэглээг сайжруулна.

3.3.4. Иргэд бие дааж үндэсний бичиг сурах, зөв сайхан бичихэд зориулж гарын авлага, толь бичиг зөвлөмжийг электрон хэлбэрээр үйлдэж гаргана.

3.3.5. Төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүсийн үүсгэл санаачилгаар зохион байгуулах монгол хэл, үндэсний бичиг сурах, сурталчлахад чиглэсэн санал, санаачилгыг дэмжиж хамтран ажиллах.

3.3.6. Төрийн албан хаагчдын компьютерт үндэсний бичгийн программ суулгаж, түүнийг ашиглаж сургах, хэрэглээ болгох мөн монгол хэлний зөв бичгийн дүрэм, журамласан үг зэргийг сайтад байршуулж нийтэд түгээнэ.

3.3.7. Аймгийн төв болон сумдын орох гарах хаалган дээрх хаягийг кирил болон үндэсний бичгээр үйлдэнэ.

3.3.8 Шинээр босгох хөшөө, дурсгал, түүхэн дурсгалт газруудад байршуулсан самбарын бичиглэлийг кирил болон үндэсний бичгээр үйлдэнэ.

**4-р зорилтын хүрээнд:**

3.4.1. Төрийн албан хаагчдын монгол хэл бичгийн чадварын түвшинг тогтооно

3.4.2 Мөрөн II, Галт сумын сургуулийг монгол хэл бичгийн сургалтыг түлхүү хөгжүүлсэн түшиц сургууль болгоно.

3.4.3. Монгол хэл, бичгийн телевизийн хичээл явуулж, иргэдийн монгол бичиг сурах идэвх сонирхлыг өрнүүлэх.

3.4.4. Орон нутгийн телевиз, радио, FM-д “Монгол хэл, бичгийн булан” нээж ажиллана.

3.4.5. “Хөвсгөлийн сайхан бичигтэн” монгол хэл, бичгийн уралдааныг иргэдийн дунд зохион байгуулж, сурталчилна.

3.4.6. “Эх хэлээ эрхэмлэгч” байгууллага, хамт олныг шалгаруулж, батламжилна.

3.4.7. Төрийн албанд шинээр ажилд орох иргэдээс монгол хэл бичгийн шалгалт авах ажлыг нэг үзүүлэлт болгоно.

3.4.8 Иргэд бие дааж үндэсний бичиг сурах, зөв сайхан бичихэд зориулж, ном сурах бичиг, гарын авлага, толь бичгийг шалгаруулах уралдааныг бүх ЕБС-ийн МХУЗ-ын багш нарын дунд нээлттэй зарлаж, шалгаруулах.

***Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт, хяналт***

5.1. “ЭХ ХЭЛ, БИЧИГ ” хөтөлбөрийн үе шат:

- 2016-2020

- 2020-2025 онд хэрэгжинэ.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд аймгийн засаг дарга, сумдад сумын засаг дарга, багт багийн засаг дарга ахалж ажиллана.

5.3. Хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайланг жил бүр шат шатны Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн биелэлт үр дүнг тооцож, холбогдох шийдвэрийг гаргаж ажиллана.

***Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт***

6.1. “Үндэсний хэлбичиг хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж хэрэгжилтэд хяналт тавина.

6.2. Хөтөлбөрийн холбогдох заалтыг төсвийн ерөнхийлөн захирагчаас сумын засаг даргатай байгуулах гэрээнд тусган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

6.3. Гадаад орон, олон улсын хандивлагч байгууллагын болон иргэд, төрийн бус байгууллагын санхүүгийн дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлнэ.

### ***Долоо. Хөтөлбөрийн шалгуур, үзүүлэлт***

Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур, үзүүлэлтээр дүгнэнэ:

7.1. Монгол хэл, бичгийг багш нарын заах арга, ур чадварт ахиц гарсан байна.

7.2. Бүх байгууллага, аж ахуйн нэгжүүд хаягаа монгол, кирилл бичгээр бичиж хэвшинэ.

7.3. Төрийн захиргааны болон хэвлэл мэдээллийн байгууллагад монгол хэл, бичгийн орчин, зохистой хэрэглээ бүрдэнэ.

7.4. Монгол бичиг сурах иргэдийн сонирхол, хэрэгцээ нэмэгдэнэ.

7.5. Монгол хэл, уран зохиолын мэргэжлийн багш, ЕБС-ийн сурагчид, иргэдийн монгол хэл, бичгийн мэдлэг, чадварын түвшин ахисан байна.

**МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН БОЛОВСРОЛЫН  
АЙМГИЙН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ**

/2015/

№	Төрөл		2015 он	Хүрэх түвшин	
				2020 он	2024 он
1	Монгол хэлний аймгийн олимпиад /багш/		40.3%	60%	80%
2	Монгол бичгийн аймгийн олимпиад /багш/		60.8%	80%	90%
3	Монгол хэлний олимпиад /сурагч/		44.4%	60%	90%
4	Монгол бичгийн олимпиад /сурагч/		56,8%	80%	90%
3	Элсэлтийн ерөнхий шалгалтын гүйцэтгэлийн хувь		62.7%	70%	75%
4	Монгол хэлний улсын олимпиад		IV байр	Эхний 5 байр	
5	Монгол бичгийн улсын олимпиад		VIII байр	Эхний 5 байр	
6	Төгсөлтийн шалгалт	V анги	хангалттай-95.2% хангалтгүй- 4,8%	90-100%	
		IX анги	39.8%	60%	70%
		XII анги	71.37%	80%	90-95%

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны  
01 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар  
тогтролын 02 дугаар хавсралт

## ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

/2016-2020, 2020- 2025/

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл	Хамрах хүрээ	Арга, хэлбэр	Хугацаа	Хариуцах хүн, баг, байгууллага	Санхүүжилт	Хүрэх үр дүн
<b>Зорилт 1: Багш нарын эх хэлний боловсролын түвшинг дээшлүүлнэ.</b>							
1	Монгол хэлний багш нарын хамтын ажиллагааг "Аравт"-ын зохион байгуулалтаар хөгжүүлэх	Мэргэжлийн багш нар	Багаар	2016 оны 01-р сарын 25- аас	БСГазар		Мэргэжлийн багш нарын 13 баг бүрдэж, ажлын зохион байгуулалт сайжирна
2	Монгол хэлний багш нарын мэргэжлийг үе шаттайгаар дээшлүүлэх төлөвлөлт хийж ажиллах	МХУЗ-ын 130 багш	Сургалт, зөвлөгөөн, зайн сургалт	Жилд хоёроос доошгүй удаа	БСГазар, Сургууль	Жилд 3-5 сая төгрөг	Багш нар жилд 1-2 удаа сургалтад хамрагдсанаар онол, арга зүйн мэдлэг чадвар нэмэгдсэн байна.
3	Мэргэжлийн багш нараар дамжуулан бусад мэргэжлийн багш нарын монгол хэл бичгийн чадварыг хэрэглээний ахиулна.	МХУЗ-ын 130 багш	Сургууль бүрийн төлөвлөлтөөр	2016 оноос	БСГ, ЕБС	Жилд 500.000 төгрөг	Нийт багш нарын 90%- нь монгол бичгээр бичиг баримтаа хөтөлдөг болно.
4	Эх хэлний багш нарын судалгааны ажлыг дэмжиж, боловсролын түвшинг ахиулна. /Хэл шинжлэлийн чиглэлээр/	МХУЗ-ын багш нар	Эчнээ болон зайн сургалтаар	2016 оны 1-р улирлаас	БСГ, МУБИС	5.000.000 төгрөг	МХУЗ-ын багш нарын 70- аас доошгүй хувь нь магистрын зэрэгтэй болно.
5	Монгол хэлний багш нарын "Мэргэжил арга зүйн баг " бүрдүүлж ажиллана.	Үе үеийн багш нар	Ажлын байрны хөгжил, зөвлөмж, гарын авлага	2016 оны 1-р улирал	БСГазар	500.000 төгрөг	Багш нарын мэргэжлийн онол, арга зүйн мэдлэг чадварт ахиц гарна.



6	Мөрөн сумын монгол хэлний багш нарыг "Эх хэлний цаг" тай болгож ажиллана.	Мөрөн сумын МХУЗ-ын багш нар	Ярилцлага, хэлэлцүүлэг, сургалт	2016 оноос	БСГазар, Сургуулийн захирал		Мэргэжлийн багш нар тогтмол уулздаг зөвлөлдөх цагтай болно.
7	Багш нарын сургалтын шилдэг арга зүй, технологи, туршлагыг түгээн дэлгэрүүлж, цахим мэдээллийн санд авна.	МХУЗ-ын багш нар	Сурталчлах шагнах урамшуулах	2016 оны 2-р улирлаас	БСГ, сургууль	5.000.000 төгрөг	Шилдэг арга зүйн цахим сантай болсон байна.
8	Баруун болон төвийн бүсийн аймгийн мэргэжлийн багш нартай хамтран ажиллана.	МХУЗ-ын багш нар	Туршлага судлах, хамтран ажиллах	Жилд 1-2 удаа	ЗДТГ, БСГазар, Сургууль	20.000.000 төгрөг	Туршлага солилцох, өөрсдийн туршлагаа түгээн дэлгэрүүлэх боломж бүрдэнэ

**Зорилт 2: Суралцагчдын эх хэлний мэдлэг, чадварын түвшинг дээшлүүлнэ.**

1	ЕБС-дэд "Бичиг-урлаг" уран бичлэгийн дугуйлан хичээллүүлнэ.	ЕБС-ийн сурагчид	дугуйланга ар	7 хоногт нэг удаа	БСГ, Мөрөн 2-р сургууль, бусад сургууль	Жил бүр 500.000 төгрөг	Сургууль бүр уран бичлэгийн дугуйлантай болно.
2	"Эх хэл бидний бахархал" үндэсний бичиг соёлын өдрийг тусгай удирдамжаар тэмдэглэх	Багш, сурагчид	Эх хэлний баяр, аян	Үндэсний бичиг үсгийн баяраар	АЗДТГ, БСГазар, Мөрөн 2-р сургууль	Жил бүр 3.800.000 төгрөг	Эх хэл бичгээрээ бахархах, сурталчлах, олон нийтийн эх хэл бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажил тогтмолжино.
3	"Шидэт уянга", "Цэнхэр алс" яруу найргийн дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.	Сурагчид	дугуйланга ар	7 хоногт нэг удаа	БСГ, ДМЦС	Жил бүр 500.000 төгрөг	Дугуйлангаар дамжуулан сурагчдын ярих, уран унших, зохион найруулах, өөрийгөө илэрхийлэх зэрэг чадварыг хөгжүүлж хөмтрөн хөгжих боломж бүрдэнэ.

4	" Хэлц үгээр хэлэлцье " хүүхдийн цуврал нэвтрүүлэгтэй болно.	Сурагчид	Цуврал нэвтрүүлгэ эр	2015 оноос сард нэг удаа	АЗДТГ, БСГазар	Жил бүр 2.000.000 төгрөг	Ахлах ангийн сурагчдын эх хэлний онол болон хэрэглээний чадварт ахиц гарна.
5	Эх хэлний тулгуур дөрвөн чадварыг хөгжүүлэх дугуйлангийн суралцагчдын уулзалт, мэтэлцээн зохион байгуулна.	Сурагчид	дугуйланга ар	2016 оноос улирал бүр	БСГ, ЕБС- иуд	Жил бүр 1.000.000 төгрөг	Сурагчдын эх хэлээрээ зөв ярих, үзэл бодлоо илэрхийлэх, батлах, бусдыг сонсох зэрэг чадварыг хөгжүүлэх боломж бүрдэнэ.
6	Монгол улсын хөдөлмөрийн баатар, гавьяат багш Т.Дашцэдэнгийн нэрэмжит Эх хэлний баярыг 4 жилд нэг удаа аймгийн үндсэн чиглэлд тусгаж хэрэгжүүлнэ.	Багш, суралцагчид	Тусгай удирдамжа ар	2018, 2022 онд	АЗДТГ, БСГ, ЕБС	Жил бүр 10 сая	Эх хэлний тогтсон үйл ажиллагаатай болж, эх хэлээрээ бахархах хандлага иргэд, багш сурагчдад төлөвшинэ.
7	Суралцагчдын эх хэлний мэдлэгийн түвшинг үнэлэх жишиг даалгаврыг боловсруулж хөндлөнгийн үнэлгээ хийнэ.	Ахлах ангийн сурагчид	Жишиг даалгавра ар	Улирал бүр	БСГ, ЕБС- иуд	Жил бүр 1.000.000 төгрөг	Сурагчдын эх хэл, бичгийн мэдлэг чадвар дээшилнэ.
8	5-12-р ангийн сурагчид бага, дунд ангийн багш нарын олимпиадыг Монгол улсын гавьяат багш Д.Батсуурийн нэрэмжит болгон зохион явуулна.	багаар	олимпиад	Жилд 1 удаа	ЭДТГ, БСГ	Жил бүр 5.000.000 төгрөг	Багш сурагчдын эх хэл бичгийн онолын мэдлэг, чадварт ахиц гарна.
9	ЕБС бүрийн эх хэл бичгийн чадварыг төлөвлөгөөний биелэлт үр дүнг тооцож ажиллах	Багш, суралцагчид	Төлөвлөгө өний гүйцэтгэл эр	Жилд 1 удаа	БСГ		Тухайн сургуулийн нийт багш, сурагчдад эх хэлний хэрэглээний чадвараа боломж нэмэгдүүлэх бүрдэнэ.
10	Бүх мэргэжлийн багш нараас монгол хэл бичгийн чадварын түвшинг үнэлэх шалгалт авч ажиллах	Багш нар	Боловсруу лсан даалгавра ар	Жилд 2- оос доошгүй удаа	БСГ		Бүх мэргэжлийн багш нарын эх хэлний чадварт ахиц гарна.

Зорилт 3: Эх хэл бичгийн зөв хэрэглээ бүхий орчин бүрдүүлнэ.

1	Төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, гудамж, талбайн хаяг, бүтээгдэхүүний шошгыг кирил болон үндэсний бичгээр зөв үйлдэхийг захирамжилж хэрэгжүүлэх	Бүх аж ахуйн нэгж, байгууллага	Албан бичиг хүргүүлж, зөвлөгөө өгнө	2016 оноос	АЗДТГ БСГ	Нийт албан байгууллагууд, гудамж талбай хаягаа 100% монгол кирил бичгээр алдаагүй үйлдсэн байна.
2	Монгол хэл, бичгийн жишиг кабинетыг сумын сургууль бүрт орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр байгуулж, ажиллуулна.	ЕБС-иуд	Үйл ажиллагаага ар	2017 оноос	Сумын ЗДТГ, ЕБС	Сум бүр жишиг кабинеттэй болно.
3	Хэвлэл мэдээллийн байгууллагуудын ажилтнуудын зөв бичгийн дүрмийн хэрэглээг сайжруулна.	Хэвлэл мэдээллийн байгууллага уд	Сургалт, зөвлөгөө	2016 оноос	ЗДТГ, БСГ	Телевизийн зар, мэдээ, шторк, нэвтрүүлэг зэргийн эх зөв бичгийн дүрмийн алдаагүй үйлдэгддэг болно.
4	Иргэд бие дааж үндэсний бичиг сурах, зөв сайхан бичихэд зориулж гарын авлага, толь бичиг зөвлөмжийг электрон хэлбэрээр үйлдэж гаргана.	Иргэд, суралцагчид	Цахим хэлбэрээр	2016 оноос улиралд нэг удаа	БСГ	Иргэд монгол бичгийг бие даан суралцах боломж бүрдэнэ.
5	Төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүсийн санаачилгаар үүсгэл байгуулах монгол хэл, үндэсний бичиг сурах, сурталчлахад чиглэсэн санал, санаачилгыг дэмжиж хамтран ажиллах.	Иргэд	Үйл ажиллагаага ар	Жил бүр	ЗДТГ, БСГ	Эх хэлээ сурталчлах, өдөр тутмын зөв хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг илүү өргөн хүрээг хамруулан зохион байгуулах боломжтой болно.

6	Төрийн албан хаагчдын компьютерт үндэсний бичгийн үндэсний программ суулгаж, түүнийг ашиглаж сургах, хэрэглээ болгох мөн монгол хэлний зөв бичгийн дүрэм, журамласан үг зэргийг сайтад байршуулж нийтэд түгээнэ.	Төрийн байгууллага удад	сургалт	2015 оноос	ЗДТГ, БСГ	Жил бүр 1.000.000 төгрөг	Төрийн албан хаагчдын эх хэлээ зөв хэрэглэх чадварт ахиц гарах боломж бүрдэнэ
7	Аймгийн төв болон сумдын орох гарах хаалган дээрх хаягийг кирил болон үндэсний бичгээр үйлдэнэ.	24 сум	Үйл ажиллагаага ар	2017 оноос	ЗДТГ, БСГ, сумдын ЗДТГ	20.000.000 төгрөг	24 сумын хаяг 100% монгол бичгээр бичигдэнэ
8	Шинээр босгох хөшөө, дурсгал, түүхэн дурсгалт газруудад байршуулсан самбарын бичиглэлийг кирил болон үндэсний бичгээр үйлдэнэ	Албан байгууллага, иргэд	Үйл ажиллагаага ар	2017 оноос	ЗДТГ, сумдын ЗДТГ		Шинэ хөшөө дурсгалтуудыг 100% монгол кирил бичгээр үйлдсэн байна.
<b>Зорилт 4: Иргэдийн монгол хэл бичгийн хэрэглээний чадварыг сайжруулна.</b>							
1	Төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн чадварын түвшинг тогтооно	Нийт төрийн албан хаагчид	даалгавраар	2016 оноос	ЗДТГ, БСГ, сумын ЗДТГ		Үнэлгээнд үндэслэж төрийн албан хаагчдын онцлогт тохирсон сургалтын цахим орчин бий болно.
2	Мөрөн II, Галт сумын сургуулийг монгол хэл бичгийн сургалтыг түлхүү хөгжүүлсэн түшиц сургууль болгоно.	Иргэд олон нийт	Зөвлөгөө, сургалт	2015 оноос	БСГ, Мөрөн II, Галт ЕБС	20.000.000 төгрөг	МХУЗ-ын багш нарын хамтран хөгжих боломжийг дэмжихүйц, сургалт сурталчилгааны түшиц сургуультай болно.

3	Монгол хэл, бичгийн телевизийн хичээл явуулж, иргэдийн үндэсний бичиг сурах идэвх сонирхлыг өрнүүлнэ.	Иргэд суралцагчид	ТВ хичээл, сургалт, зөвлөгөө	2015 оны 01-р сараас	БСГазар Гэгээрэл төвүүд	Жил бүр 5.000.000 төгрөг	Иргэдийн монгол бичгийн мэдлэг чадвар, хандлагад ахиц гарна.
4	Орон нутгийн телевиз, радио, FM-д "Монгол хэл, бичгийн булан" нээж ажиллана.	Хэвлэл мэдээллийн байгууллагууд	Зайн сургалтаар	2016 оноос эхлэн улирал тутам	БСГ, Мэргэжлийн багш нарын баг	Жил бүр 1.000.000 төгрөг	Сургалтын цахим орчин бүрдэнэ.
5	"Хөвсгөлийн сайхан бичигтэн" монгол хэл, бичгийн уралдааныг иргэдийн дунд зохион байгуулж, сурталчилна.	Иргэд суралцагчид	сурталчилга а	2016 оны 2-р улирлаас	ЗДТГ, БСГазар	Жил бүр 2.000.000 төгрөг	Иргэдийн эх хэл, бичиг соёлоо хүндэтгэх, түүгээр бахархах үзэл хандлага нэмэгдэнэ.
6	"Эх хэлээ эрхэмлэгч" байгууллага, хамт олныг шалгаруулж, батламжилна.	Байгууллагууд	Сум бүрээр	2016 оноос	ЗДТГ, БСГазар	Жил бүр 5.000.000 төгрөг	Байгууллага хамт олноороо хөгжих боломж бүрдэнэ.
7	Төрийн албанд шинээр ажилд орох иргэдээс монгол хэл, бичгийн шалгалт авах ажлыг нэг үзүүлэлт болгоно.	Байгууллагууд	Бичгээр, цахимгаар	2015 оноос	ЗДТГ, БСГазар,		Монгол хэл, бичгийн чадварын үзүүлэлт журамд тусгагдаж хэрэгжинэ.
8	Иргэд бие дааж үндэсний бичиг сурах, зөв сайхан бичихэд зориулж, ном сурах бичиг, гарын авлага, толь бичгийг шалгаруулах уралдааныг бүх ЕБС-ийн МХУЗ-ын багш нарын дунд нээлттэй зарлаж, шалгаруулах.	МХУЗ-ын 130 багш	Цахим, ном	2016 оноос	ЗДТГ, БСГазар	2.000.000 төгрөг	Иргэд бие даан монгол бичиг сурах загвар бүхий гарын авлагатай болно.
Жилд гарах зардлын тооцоо							132.800.000 төгрөг